## Таньд хэрэгтэй мэдээлэл

Тус "Хураангуй гарын авлага" нь "Хэрэглэгчийн гарын авлага"-г орлохгүй.

Таны автомашины хүчин чадал, хязгаарын тухай мэдээллийг өгөх тул бид бүхэн таниас "Хэрэглэгчийн гарын авлага"-г уншихыг хичээнгүйлэн хүсч байна.

Техник үзүүлэлтээс хамаарч зурагт үзүүлсэн автомашин таны автомашинаас тоноглолын хувьд өөр байж болно.

# Зурган индекс

## Хянах самбар (Баруун жолооны хүрдтэй автомашин)




A **Асаах товч** ........ **Х.20**

Хөдөлгүүр асаах/асаах товчны горим солих ........ Х.20

Онцгой нөхцөл байдалд хөдөлгүүр унтраах ........ Х.21

Хөдөлгүүр асахгүй үед*1

Анхааруулах мэдээлэл*1

B **Арааны хөшүүрэг** ........ **Х.22,23**

Арааны хөшүүрэг шилжүүлэх ........ Х.24,25

Чирүүлэх үеийн анхааруулга*1

Арааны хөшүүрэг шилжихгүй байгаа үед*1

C **Хэмжих хэрэгслүүд*1**

Хянах самбарын хэмжих хэрэгслүүд/Хянах самбарын гэрлийн тохиргоо*1

Анхааруулах гэрэл/индикаторууд ........ Х.73

Анхааруулах гэрэл ассан үед*1

D **Мэдээллийн дэлгэц** ........ **Х.34**

*1 : Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

Дэлгэц ........ Х.34

Анхааруулах мэдээлэл гарсан үед*1

E **Эргэх дохионы хөшүүрэг/Их гэрлийн асаагуур ........ Х.30,37**

Их гэрэл/урд оврын гэрэл/арын гэрэл/дугаарын гэрэл/өдрийн хөдөлгөөний гэрэл ........ Х.37

Урд манангийн гэрэл*/Хойд манангийн гэрэл*1

F **Шил арчигч ба шил угаагч ........ Х.41,42**

Ашиглалт ........ Х.41,42

Шил арчигчийн шингэн нэмэх*1

Анхааруулах мэдээлэл*1

G **Ослын дохионы гэрлийн товч*1**

H **Капот нээх хөшүүрэг*1**

I **Жолооны хүрд тохируулах товч**1**

Тохиргоо хийх*1

Жолоодлогын байрлал санах ой*1

J **Жолооны хүрд тохируулах хөшүүрэг**1**

Тохиргоо хийх*1

K **Агааржуултын систем ........ Х.55**

Ашиглалт ........ Х.55

Арын цонхны цан арилгагч

L **Аудио систем**

* :Тоноглогдсон автомашинд

## Товч (Зүүн жолооны хүрдтэй автомашин)




A Хянах самбарын гэрлийн удирдлагын товч

B ODO/TRIP товч

C Камерны товч**3

D Шатахууны савны таг нээх товч.................................................... Х.72

E Тээшний автомат хаалганы товч* ................................................ Х.70

F Жолоодлогын байрлал санах ойн товч**2

G Хажуугийн толины товч*2

H Хаалга түгжих товч ............................................................................. Х.61

I Автомат цонхны товч........................................................................ Х.64

J Цонх түгжих товч*2............................................................................. Х.65

*2 : Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

* : Тоноглогдсон автомашинд

*3 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.




A Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг ................ Х.26,27,28,29

B Хянах самбарын удирдлагын товч ................................................ Х.35

C Хурд баригчийн товч*2

Динамик радарын хурд баригч*2

D Аудио зайнаас удирдах товч*4*2

E LTA товч*2

F Гар утасны товч*5

G Дуудлага хийх, яриаг дуусгах товч*6

H Аудио зайнаас удирдах товч/гар утасны товч/дуудлага хийх, яриаг дуусгах товч*7 ............................................................ Х.35

I Товчны функц өөрчлөх товч ........................................................... Х.35

*4 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*5 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*6 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*7 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.




A Жолоодлогын горим сонгох товч .................................................. Х.43
B P байрлалын товч**2 ............................................................. Х.24
C Тоормос баригчийн товч*2 ........................................................ Х.33
D Stop & Start cancel товч**2
E DAC товч*
F VSC OFF товч*2
G Trail горимын товч*
H Зогсоолын тоормосны товч ................................................ Х.24,31,33
Зогсоолын тоормос залгах/салгах........................................ Х.24,31,33
Өвлийн улирлын анхааруулга*2
Анхааруулах дуут дохио/мэдээлэл*2

## Дотор тал (Зүүн жолооны хүрдтэй автомашин)




- A SRS аюулгүйн дэр*8
- B Шалавч ........................................................................................... Х.17
- C Урд суудал*8
- D Арын суудал*8
- E Толгойн түшлэг*8
- F Аюулгүйн бүс*8
- G Голын хайрцаг*8
- H Аяганы тавиур*8
- I Туслах бариул*8

*8 : Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

## Дээд тал (Зүүн жолооны хүрдтэй автомашин)




A Голын толь*9

B Нарны хаалт*10*9

C Гоо сайхны толь*9

*9 : Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

*10 : Тайваниас бусад: ХҮҮХДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛАХ аюултай тул аюулгүйн дэрний дэлгэгдэх хүрээнд хүүхдийн суудал АРАГШ харуулан суурилуулахыг ХАТУУ ХОРИГЛОНО.




Тайвань: Урд зорчигчийн суудалд нялх, бага насны хүүхэд ОГТ СУУЛГАЖ БОЛОХГҮЙ. Урд суудлаас бусад суудалд ХҮҮХДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛАХ аюултай тул аюулгүйн дэрний дэлгэгдэх хүрээнд хүүхдийн суудал АРАГШ харуулан суурилуулахыг ХАТУУ ХОРИГЛОНО.



D Туслах хайрцаг*9

E Дээврийн нээлхийн товч*/Панорамик дээврийн нээлхийн товч**9 ............................................................................................ Х.67

F Салоны гэрэл/Хувийн гэрэл*9

G [SOS] товч**9

H Хаалгатай холбоотой салоны гэрлийн товч*9

I Гаражны хаалга нээгчийн товч*

* :Тоноглогдсон автомашинд

## Хянах самбар (Баруун жолооны хүрдтэй автомашин)




A **Асаах товч ........ Х.20**

Хөдөлгүүр асаах/асаах товчны горим солих ........ Х.20

Хөдөлгүүр онцгой нөхцөлд унтраах ........ Х.21

Хөдөлгүүр асахгүй үед*11

Анхааруулга*11

B **Арааны хөшүүрэг*11 ........ Х.22,23**

Арааны байрлал солих ........ Х.24,25

Чирүүлэх үеийн анхааруулга*11

C **Хянах самбар**

Хянах самбарын заалт/хянах самбарын гэрэл тохируулах

Анхааруулах гэрэл/индикатор ........ Х.73

Анхааруулах гэрэл ассан үед*11

D **Мэдээллийн дэлгэц ........ Х.34**

Дэлгэц ........ Х.34

Дэлгэц дээр анхааруулга гарсан үед*11

E **Эргэх дохионы хөшүүрэг/их гэрлийн асаагуур ........ Х.30,37**

*11 :Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

Их гэрэл/урд оврын гэрэл/оврын гэрэл/дугаарын гэрэл/өдрийн хөдөлгөөний гэрэл .......... Х.37

Урд манангийн гэрэл*/Арын манангийн гэрэл*11

F **Шил арчигч, угаагчийн товч .......... Х.41,42**

Ашиглалт .......... Х.41,42

Шил арчигчийн шингэн нэмэх*11

Анхааруулга*11

G **Ослын дохионы гэрлийн товч*11**

H **Капот нээх хөшүүрэг*11**

I **Жолооны хүрдний тохиргооны товч*11**

Тохиргоо*11

Жолоодлогын байрлал санах ой*11

J **Агааржуулалтын систем .......... Х.55**

Ашиглалт .......... Х.55

Арын цонхны цан арилгагч*11

K **Аудио систем*12**

* : Тоноглогдсон автомашинд

*12 : Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

## Товч (Баруун жолооны хүрдтэй автомашин)




A Хянах самбарын гэрлийн удирдлагын товч

B ODO/TRIP товч

C Камерны товч**14

D Шатахууны савны таг нээх товч.................................................... Х.72

E Тээшний автомат хаалганы товч**13 ........................................... Х.70

F Жолоодлогын байрлал санах ойн товч*13

G Хажуугийн толины товч*13

H Хаалга түгжих товч ............................................................................ Х.61

I Автомат цонхны товч......................................................................... Х.64

J Цонх түгжих товч*13 .......................................................................... Х.65

*13 :Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

* :Тоноглогдсон автомашинд

*14 :Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.




A Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг................X.26,27,28,29

B Хянах самбарын товч........................................................................ X.35

C Хурд баригчийн товч*13

Динамик радарын хурд баригч*13

D Аудио систем зайнаас удирдах товч*15*13

E LTA (Lane Tracing Assist) товч*13

F Утасны товч*16

G Talk товч*17

H Аудио систем зайнаас удирдах товч/утасны товч/дуудлага товч*18 ........................................................................................ X.35

I Товчны функц өөрчлөх товч........................................................... X.35

*15 :Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*16 :Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*17 :Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*18 :Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.




A Жолоодлогын горим сонгох товч .................................................. Х.43

B P байрлалын товч*13 ........................................................................ Х.24

C Тоормос баригчийн товч*13 ............................................................ Х.33

D VSC OFF товч*13

E Trail горимын товч*

F Stop & Start cancel товч*13

G DAC товч*

H Зогсоолын тоормосны товч .................................................. Х.24,31,33

Залгах/салгах ............................................................................ Х.24,31,33

Өвлийн улирлын анхааруулга*13

Анхааруулах дохио/мэдээлэл*13

## Дотор тал (Баруун жолооны хүрдтэй автомашин)




A SRS аюулгүйн дэр*19

B Шалавч ........ Х.17

C Урд суудал*19

D Арын суудал*19

E Толгойн түшлэг*19

F Аюулгүйн бүс*19

G Голын хайрцаг*19

H Аяганы тавиур*19

I Туслах бариул*19

*19 :Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

## Дээд тал (Баруун жолооны хүрдтэй автомашин)




A Голын толь*20

B Нарны хаалт*21*20

C Гоо сайхны толь*20

D Туслах хайрцаг*20

E Дээврийн нээлхийн товч*/Панорамик дээврийн нээлхийн товч**20 ........ Х.67

F Салоны гэрэл/Хувийн гэрэл*20

G Хаалгатай холбоотой салоны гэрлийн товч*20

*20 :Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

*21 :ХҮҮХДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛАХ АЮУЛТАЙ тул ИДЭВХТЭЙ АЮУЛГҮЙН ДЭРНИЙ дэлгэгдэх хүрээнд хүүхдийн суудал АРАГШ харуулан суурилуулахыг ХАТУУ ХОРИГЛОНО.




* :Тоноглогдсон автомашинд

## Шалавч зөв ашиглах

Зөвхөн адил төрлийн нэг оны загварт зориулагдсан шалавч ашиглана. Шалавчийг хивсэнцэр дээр зөв байрлалд угсрана.

### Шалавч угсрах

1 **Бэхлэх дэгээ (хавчаар)-г шалавчны нүхэнд хийнэ.**



2 **Бэхлэх дэгээ (хавчаар) тус бүрийн дээд товчийг эргүүлж шалавч тогтооно.**

Тогтоох үед △ болон A тэмдгийг тааруулна.

Бэхлэх дэгээ (хавчаар)-ний хэлбэр зурагт үзүүлснээс өөр байж болно.



## Түлхүүрийн төрлүүд

Автомашинд дараах түлхүүрүүд дагалдаж ирнэ.




A Электрон түлхүүр

- Smart entry & start системийн ажиллагаа
- Түлхүүрийн алсын удирдлаганы ажиллагаа

B Механик түлхүүр

C Түлхүүрийн дугаар бүхий пайз

D Түлхүүр карт (электрон түлхүүр)*

Smart entry & start системийн ажиллагаа

* :Тоноглогдсон автомашинд

# Smart entry & start систем

## Smart entry & start системээр хаалга түгжих, тайлах

Жолооч электрон түлхүүр (эсвэл түлхүүр карт)-г халаасандаа зэргээр цаг ямагт биедээ авч явна.




1 Хаалганы бариулаас атгаж түгжээ тайлна.*1

Бариулны ард талын мэдрэгчид хүрнэ.

Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундын дотор түгжээ тайлагдахгүй.

2 Түгжих мэдрэгчид (хаалганы бариулын хонхор хэсэг) хүрч хаалга түгжинэ.

Хаалга бүрэн түгжигдсэн байгааг нягтлана.

## Smart entry & start системээр тээшний хаалга нээх

### Smart entry & start системээр тээшний хаалга түгжих/тайлах




1 1-г дарна.

Бүх хаалганы түгжээ тайлагдана. Нөгөөтэйгүүр хаалга түгжсэн үед 3 секундын дотор тайлагдахгүй.

2 2-г дарна.

Бүх хаалга түгжигдэнэ. Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг нягтлана.

*1 :Хаалганы түгжээ тайлах тохиргоог өөрчлөх боломжтой.

# Хөдөлгүүр асаах

Электрон түлхүүртэй үед дараах үйлдлээр хөдөлгүүр асаах, эсвэл асаах товчны горим солих боломжтой.

## Хөдөлгүүр асаах

1 **Зогсоолын тоормос залгагдсан байгааг нягтлана.**

Зогсоолын тоормосны индикатор асна.

2 **Тоормосны дөрөө сайтар гишгэнэ.**

 болон мэдээлэл нь мэдээллийн дэлгэц дээр гарна. Дэлгэц дээр гараагүй үед хөдөлгүүр асах боломжгүй.

3 **Асаах товчийг богино, чанга дарна.**




Асаах товч ажиллуулах үед нэг удаа богино, чанга дарахад хангалттай. Товчийг удаан дарах шаардлагагүй.

Стартер мотор хөдөлгүүр асах хүртэл ажиллах, асаагүй нөхцөлд 30 секунд ажиллана.

Хөдөлгүүр бүрэн асах хүртэл тоормосны дөрөөг үргэлжлүүлэн асна.

Хөдөлгүүрийг асаах товчны аль ч горимоос асааж болно.

## Асаах товчны горим солих

Тоормосны дөрөө гишгэн асаах товч дарж горим солих боломжтой. (Товч дарах бүрт горим солигдоно.)




1 OFF

Ослын дохионы гэрэл ашиглах боломжтой.

2 ACC *1

Аудио хөгжим зэрэг зарим электрон төхөөрөмж ашиглах боломжтой. **"ACCESSORY"** мэдээллийн дэлгэц дээр гарна.

3 ON

Бух электрон төхөөрөмж ашиглах боломжтой.

**"IGNITION ON"** мэдээллийн дэлгэц дээр гарна.

## Автомашиныг онцгой нөхцөлд зогсоох

Автомашиныг хэвийн байдлаар зогсоох боломжгүй болсон зэрэг зөвхөн онцгой, ослын нөхцөл үүссэн үед дараах дарааллаар зогсооно:

**1 Тоормосны дөрөөг 2 хөлөөрөө чанга үргэлжлүүлэн гишгэнэ.**

Автомашиныг зогсооход шаардагдах тоормосны үйлчилгээ буурдаг тул тоормосны дөрөөг олон дахин гишгэж болохгүй.

**2 Арааг N байрлалд шилжүүлнэ.**




- Араа N байрлалд шилжсэн үед:

  Хурд буурсны дараа замын хажуу талд аюулгүй газарт зогсооно.

  Хөдөлгүүрийг унтраана.

- Арааг N байрлалд шилжүүлж болохгүй үед:

  Автомашины хурдыг боломжит хэмжээнд хамгийн ихээр бууруулахын тулд тоормосны дөрөөг 2 хөлөөрөө үргэлжлүүлэн гишгэнэ.

  Асаах товчийг 2 ба түүнээс дээш секунд үргэлжлүүлэн дарах, эсвэл 3 ба түүнээс олон удаа богино хугацаанд товчийг дарж хөдөлгүүр унтраана.

**3 Замын хажуу талд аюулгүй газарт зогсооно.**

*1 : Өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэн/цуцлах боломжтой.

## Арааны байрлалын ашиглалтын зориулалт (Автомат хурдны хайрцаг)

Өөрийн зорилго, тухайн нөхцөл байдалд нийцүүлэн арааны байрлал сонгоно.

| Арааны байрлал | Зориулалт ба функц |
|---|---|
| P | Зогсоолд байрлуулах/хөдөлгүүр асаах |
| R | Ухрах |
| N | Сул араа |
| D | Хэвийн жолоодлого(1) |
| M | M горимын жолоодлого(2) |

(1) Шатахуун зарцуулалтын сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогын үед D арааг сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр жолоодлогын нөхцөл байдалдаа нийцүүлэн араа солих боломжтой.

(2) Жолоодлогын M горим сонгосон үед арааг хязгаарлах боломжтой.

## Арааны байрлал бүрийн зориулалт (CVT хурдны хайрцаг)

Арааны байрлалыг эдгээрийн зориулалт болон нөхцөл байдалд нийцүүлэн сонгоно.

### ■ Арааны байрлалын зориулалт болон функц

| Арааны байрлал | Зориулалт, функц |
|---|---|
| P | Автомашиныг зогсоолд байрлуулах/хөдөлгүүр асаах |
| R | Ухрах |
| N | Сул араа |
| D | Хэвийн жолоодлого(1) |
| M | 10 шатлалт спорт горимоор жолоодох(2) |

(1) Шатахуун зарцуулалт сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогод арааны D байрлал сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр жолоодлогын нөхцөлд нийцүүлэн араа сонгох боломжтой.

(2) Арааны M байрлалд араа сонгосноор хурд нэмэх болон хөдөлгүүрийн тоормосны хүчийг удирдах боломжтой.

# Арааны байрлал солих (автомат хурдны хайрцаг)

## Арааны байрлалын дэлгэц болон араа сэлгэх




A Арааны хөшүүрэг

Арааны хөшүүргийг арааны байрлалын индикаторын сумны дагуу зөөлөн шилжүүлнэ.

N араанд шилжүүлэх үед арааг сумны дагуу шилжүүлээд барина.

Арааг тухайн байрлалд шилжүүлсний дараа хөшүүрэг анхны байрлалд буцна (●).

M байрлалд зөвхөн арааны D байрлалаас шилжих боломжтой.

P-с N, D эсвэл R, N, D, M, эсвэл R-с P, D, эсвэл M-с R, R-с D-д шилжүүлэх үед тоормос гишгэн хөдөлгөөнгүй зогсоно.

B Арааны байрлалын индикатор

**Хянах самбарын дэлгэц:**

Одоогийн арааны байрлал асна.

**Арааны хөшүүргийн байрлал:**

Одоогийн арааны байрлалыг харуулна.

Арааны байрлал сонгох үед тухайн араанд бүрэн шилжсэн байгааг хянах самбар дээр гарч буй арааны байрлалаар нягтлана.

C P байрлалын товч

Автомашиныг бүрэн зогсоож зогсоолын тоормос залгаад P байрлалын товч дарна.

Араа P байрлалд шилжих үед индикатор асна.

Арааны байрлалын индикатор P болсныг нягтлана.

# Арааны байрлал солих (CVT хурдны хайрцаг)

## Арааны хөшүүрэг шилжүүлэх

Асаах товчны ON горимд тоормосны дөрөө гишгээд*2 араа суллах товч дарангаа арааны хөшүүргийг шилжүүлнэ.

Араа суллах товчийг дарангаа арааны хөшүүргийг шилжүүлнэ.

Арааны хөшүүргийг хэвийн байдлаар шилжүүлнэ.

Арааг P болон D хооронд сэлгэх үед автомашин бүрэн зогссон байх шаардлагатай.




*2 : Араа суллах товч дарахаас өмнө эхлээд тоормос гишгэхэд арааг P байрлалаас шилжүүлэх боломжтой. Араа суллах товчийг эхлээд дарсан үед араа шилжихгүй.

# Араа солих (Автомат хурдны хайрцаг)

## Арааны D байрлалд арааны шатлал сонгох

D араатай үед арааг түр өөрчлөн [**-**] жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулна.

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [**-**] болон [**+**] талыг дарж арааны шатлал сонгоно.




1 Хөнгөн ааранд шилжүүлэх
2 Хүнд ааранд шилжүүлэх

Мэдээллийн дэлгэц дээр D1-с D8 хүртэлх арааны шатлалыг харуулна.

D байрлалд буцах үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [**+**] товчийг доош удаан дарна.

- Мэдээллийн дэлгэц дээр D2-с D8 хүртэлх арааны шатлал гарсан үед автомашины хурд болон жолоодлогын байдалд нийцүүлэн 1-р арааанаас тухайн араа хүртэлх арааны хооронд хурдны хайрцаг автоматаар шилжинэ.
- Мэдээллийн дэлгэц дээр D1 гарсан үед зөвхөн 1-р араа сонгогдоно.

  Хөнгөн араатай харьцуулахад хүнд араа нь илүү хүчтэй хөдөлгүүрийн тоормосны хүч үүсгэнэ.

# Араа солих (CVT хурдны хайрцаг)

## Арааны D байрлалд араа солих

D араатай үед арааг түр өөрчлөн жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн аль нэг талыг дарна.

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [**-**] болон [**+**] талыг дарж араа солино.




**1** Хөнгөн арааnd шилжүүлэх
**2** Хүнд арааnd шилжүүлэх

Мэдээллийн дэлгэц дээр D1-с D10 хүртэлх арааны шатлалыг харуулна.

D байрлалд буцах үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [**+**] товчийг удаан дарна.

● Арааны шатлалууд ба тэдгээрийн функц

- Хурд нэмэх, хөдөлгүүрийн тоормос хийх 10 шатлалт араа сонгоно.
- Доод араанууд нь дээд араануудаас илүү хүчтэй хурд нэмэх, хөдөлгүүрийн тоормос хийх хүчтэй ба хөдөлгүүрийн эргэлт мөн нэмэгдэнэ.

# Араа солих (Автомат хурдны хайрцаг)

## M горимд араа солих

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] товчоор араа солих боломжтой.




1 Хөнгөн араанд шилжүүлэх
2 Хүнд араанд шилжүүлэх

Хөшүүргийг ажиллуулах бүр араа нэг байрлалаар өөрчлөгдөнө.

Тухайн сонгосон M1-с M8 араа мэдээллийн дэлгэц дээр гарна.

Тус горим сонгогдсон үед арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулаагүй үед араа солигдохгүй.

Нөгөөтэйгүүр M байрлал сонгогдсон ч дараах нөхцлүүдэд араа автоматаар шилжинэ:

- Автомашины хурд буурах үед (зөвхөн хүнд араанд).
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм бага, эсвэл автомат хурдны хайрцагны шингэний хэм хэт бага үед.
- Автомат хурдны хайрцагны шингэний хэм хэт өндөр үед (зөвхөн хөнгөн араанд).
- Тахометрын зүү улаан бүсэд орсон (зөвшөөрөгдөх хөдөлгүүрийн хурдаас давсан).

Дараах нөхцлүүдэд жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулсан ч араа шилжихгүй.

- Автомашины хурд бага (зөвхөн хөнгөн араанд).

# Араа солих (CVT хурдны хайрцаг)

## М горимд араа сонгох

Арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] товчоор араа солих боломжтой.




1 Хөнгөн араанд шилжүүлэх
2 Хүнд араанд шилжүүлэх

Хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулах бүр араа нэг байрлалаар өөрчлөгдөнө.

Тухайн сонгосон M1-с M10 араа мэдээллийн дэлгэц дээр гарна.

Арааны хөшүүрэг M горимд байгаа ч арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулаагүй үед араа солигдохгүй.

Нөгөөтэйгүүр M байрлал сонгогдсон ч хөдөлгүүрийн хурдаас хамаарч араа автоматаар солигдож болно.

## Баруун зүүн эргэх, эгнээгээ солих үеийн ажиллагаа




1 Хөшүүргийг 1 байрлалд шилжүүлнэ.

Баруун эргэх дохионы гэрэл анивчина.

2 Хөшүүргийг 2 байрлалд түлхээд суллана.

Баруун эргэх дохионы гэрэл 3 анивчина.

3 Хөшүүргийг 3 байрлалд түлхээд суллана.

Зүүн эргэх дохионы гэрэл 3 анивчина.

4 Хөшүүргийг 4 байрлалд шилжүүлнэ.

Зүүн эргэх дохионы гэрэл анивчина.

# Автомашиныг зогсоолд байрлуулах

## Автомашин зогсоолд байрлуулах

1 **Тоормос гишгэж автомашиныг бүрэн зогсооно.**

2 **Зогсоолын тоормос залгагдаагүй үед залгана.**

3 **Арааг P-д шилжүүлнэ.**

Арааны хөшүүргийн P байрлалын индикатор болон зогсоолын тоормосны индикатор ассаныг нягтлана.

4 **Асаах товч дарж хөдөлгүүр унтраана.**

5 **Тоормосны дөрөөг аажмаар суллана.**

6 **Хаалга түгжиж электрон түлхүүрийг биедээ авснаа нягтлана.**

### Зогсоолын тоормосны ажиллагаа

Зогсоолын тоормосыг автоматаар (автомат горим), эсвэл гар аргаар (гар ажиллагааны горим), татах, салгах боломжтой. Автомат горимд арааны хөшүүргийн ажиллагаанаас хамаарч зогсоолын тоормос автоматаар идэвхжих буюу салгагдана. Мөн автомат горимд гар аргаар ажиллуулах боломжтой.

#### Зогсоолын тоормос автоматаар залгагдах/салгагдах (авто горим)

Автомашин зогсон үед зогсоолын тоормосны товчийг **"EPB Shift Interlock Function Activated"** мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарах хүртэл татна.

Автомат горим асах үед зогсоолын тоормос дараах байдлаар ажиллана.

- Арааг P-с шилжүүлэх үед: Зогсоолын тоормос салгагдах ба зогсоолын тоормосны индикатор унтарна.
- Арааг P-д шилжүүлэх үед: Зогсоолын тоормос залгагдах ба зогсоолын тоормосны индикатор асна.

Тоормосны дөрөө гишгэн арааны хөшүүргийг сэлгэнэ.

#### Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)

Зогсоолын тоормосыг гар аргаар залгах, мөн салгах боломжтой.




**1** Товчийг татаж зогсоолын тоормос залгана.

Зогсоолын тоормосны индикатор асна.

Жолоодлогын үед онцгой нөхцөл үүссэн ба зогсоолын тоормос ажиллуулах шаардлагатай үед товчийг удаан татна.

**2** Товчийг дарж зогсоолын тоормос салгана.

- Тоормосны дөрөө гишгэнгээ зогсоолын тоормосны товч ажиллуулна.
- Зогсоолын тоормос автоматаар салгах функцаар хаазны дөрөө гишгэн зогсоолын тоормос салгах боломжтой.

Зогсоолын тоормос автоматаар салгах функц

Зогсоолын тоормосны индикатор болон зогсоолын тоормосны товчны индикатор унтарсан байгааг нягтлана.

Зогсоолын тоормосны индикатор анивчсан үед товчийг дахин ажиллуулна.

# Тоормос баригч систем

## Тоормос баригч асаах

Арааны хөшүүрэг D, M, эсвэл N арааны байрлалд байгаа ба тоормосны дөрөөгөөр автомашин зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн баридаг. Систем нь арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөний зөөлөн эхлэх боломж бүрдүүлж тоормос сулладаг.

Арааны хөшүүрэг D, M, эсвэл N арааны байрлалд байгаа ба тоормосны дөрөөгөөр автомашин зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн баридаг. Систем нь арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөний зөөлөн эхлэх боломж бүрдүүлж тоормос сулладаг.

Тоормос баригчийг асаах

Тоормос баригчийн индикатор (ногоон) асна. Систем тоормос барих үед тоормос баригчийн ажиллагааны индикатор (шар) асна.



# Дэлгэцийн функцууд

## Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцгүй автомашин)

Жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл гаргах боломжтой. Нөхцөл байдлаас хамаарч анхааруулга, эсвэл автоматаар гарч ирдэг дэлгэц мөн гарна.

### ■ Дэлгэцийн мэдээллийн хэсэг дээр гарах зүйлс

Мэдээллийн дэлгэц дээр меню тэмдэг сонгосон үед дараах зүйлсийг гаргах боломжтой.

- 

  Жолоодлогын мэдээллийн дэлгэц
- 

  Навигацийн системтэй холбоотой дэлгэц*
- 

  Аудио системтэй холбоотой дэлгэц
- 

  Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц
- 

  Анхааруулах мэдээлэл

Автомашины аль нэг системд доголдол илэрсэн үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулах мэдээлэл гарна.

## Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцтэй автомашин)

Жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл гаргах боломжтой. Нөхцөл байдлаас хамаарч анхааруулга, эсвэл автоматаар гардаг дэлгэц мөн гарна.

### ■ Дэлгэцийн мэдээллийн хэсэгт гарах зүйлс

Дараах мэдээлэл гаргах боломжтой.

- Жолоодлогын мэдээлэл 1
- Жолоодлогын мэдээлэл 2
- Эко жолоодлогын индикатор

*:Тоноглогдсон автомашинд

- Аудио системтэй холбоотой дэлгэц
- Навигацийн системтэй холбоотой дэлгэц**3
- Хүчлүүрийн хэмжүүр/хөдөлгүүрийн тосны температур хэмжигч/хөдөлгүүр тосны даралт хэмжигч*
- G-хүч
- Арааны байрлал
- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц*3
- Хоосон (дэлгэц дээр дүр гарахгүй)

Автомашины аль нэг системд хэвийн бус байдал мэдрэгдсэн үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна.

## Дэлгэцээр харуулах агуулга

### Хянах самбар/дэлгэц удирдах

▶ HUD дэлгэцгүй автомашин




A ‹ / › : Меню тэмдэг сонгоно

˄ / ˅ : Дэлгэцээр харуулах зүйлийг солих, дэлгэцийг дээш/доош гүйлгэх, курсорыг дээш/доош хөдөлгөх

B Орох/Сонгох

C Өмнөх дэлгэцэнд буцна

D Дуудлага хийх/хүлээн авах

Гарны оролцоогүй дуудлага хийх, хүлээн авах систем дэлгэц дээр гарна. Гарны оролцоогүй системийн тухай дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

* : Тоноглогдсон автомашинд

*3 : Дэлгэцийн горимыг хамгийн их тохиргоонд хийсэн үед HUD дэлгэц дээр гарна.

▶ HUD дэлгэцтэй автомашин




A Тухайн нөхцөл болон тохиргооноос хамаарч товч бүрийн функц өөр байна.

Товчинд хүрэх үед HUD дэлгэц дээр товч тус бүрийн функц гарна. HUD унтраасан үед мэдээллийн дэлгэц дээр товч тус бүрийн функц гарна.

Мөн голын дэлгэц дээр товч тус бүрийг өөрийн хүссэн функцаар тохируулах боломжтой.

B Товч дарах бүрт функц өөрчлөгдөнө.

C Тэмдгийн дэлгэцийн товч

Товч тус бүрийн тэмдэг дэлгэцээр гарна. Гараар хүрсэн товч тодорно. (E)

D Товчны функцийн зааварчилгааны дэлгэц

Гараар хүрсэн товчны функцийн зааварчилгаа дэлгэц дээр гарна.

# Их гэрэл ашиглах

Их гэрлийг гар аргаар болон автоматаар ажиллуулах боломжтой.

## Их гэрэл асаах, унтраах

▶ A төрөл




1. Урд оврын, оврын, дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
2. Их гэрэл болон дээрх бүх гэрэл асна.
3. AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээрх бүх гэрэл автоматаар асч унтарна.

▶ B төрөл




1. Урд оврын, оврын, дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
2. Их гэрэл болон дээрх бүх гэрэл асна.
3. AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээрх бүх гэрэл автоматаар асч унтарна.
4. Өдрийн хөдөлгөөний гэрэл асна.

## Холын гэрэл асаах




1 Их гэрэл асаалттай үед хөшүүргийг урагш түлхэнэ.

Холын гэрэл асна.

Хөшүүргийг анхны байрлалд буцааж холын гэрэл унтраана.

2 Хөшүүргийг нааш татаад суллана.

Холын гэрэл 1 удаа анивчина.

Их гэрэл унтраастай үед ч энэ аргаар холын гэрэл асаах боломжтой.

## AHB автомат холын гэрэл

Автомат холын гэрэл нь салхины шилний дээд талд байрлах урд камер ашиглан урд талын автомашин, замын гэрэлтүүлэг зэргийн гэрлийн түвшинг мэдэрдэг ба их гэрлийг холын болон ойрын гэрэлд автоматаар шилжүүлдэг.

### Автомат холын гэрлийн систем ашиглах

**1 Автомат холын гэрлийн товч дарна.**



**2 Их гэрлийн асаагуурыг [AUTO], эсвэл [] байрлалд шилжүүлнэ.**

Их гэрлийн хөшүүрэг ойрын гэрлийн байрлалд байгаа үед AHS систем идэвхжих ба AHB индикатор асна.



### Холын гэрлийг гараар асаах, унтраах

■ **Холын гэрэлд шилжүүлэх**

● **Хөшүүргийг урагш түлхэнэ.**

Автомат холын гэрлийн индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

Хөшүүргийг анхны байрлалд татаж автомат холын гэрлийн системийг дахин идэвхжүүлнэ.



### ■ Ойрын гэрэлд шилжүүлэх

● **Автомат холын гэрлийн товч дарна.**



Автомат холын гэрлийн индикатор унтарна.

Товч дахин дарж автомат холын гэрлийг идэвхжүүлнэ.

## Ойрын гэрэлд түр шилжүүлэх

Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй, эсвэл холын гэрэл нь бусад жолооч, явган зорчигчид хүндрэл учруулж болзошгүй үед ойрын гэрэлд шилжүүлэхийг зөвлөж байна.

● **Хөшүүргийг арагш татаад анхны байрлалд буцаана.**



Хөшүүргийг татах хугацаанд холын гэрэл асах ба анхны байрлалд буцаах үед ойрын гэрэл тодорхой хугацаанд асна. Үргэлжлээд автомат холын гэрлийн систем ажиллана.

# Бороотой үеийн харагдах байдлыг хангах

## Урд шил арчигч ашиглах

### ■ Ажиллах давтамжийг тохируулдаг тасалдсан горимтой шил арчигч*




1 ○ Off
2 Тасалдсан горим
3 ▼ Удаан
4 Хурдан
5 △ Нэг удаа арчих

### ■ Бороо мэдрэгчтэй шил арчигч*




1 ○ Off
2 AUTO Бороо мэдрэгчийн ажиллагаа

Мэдрэгч бороо мэдрэх үед шил арчигч автоматаар ажиллана. Борооны хэмжээ болон автомашины хурдад нийцүүлэн систем автоматаар шил арчигчийн ажиллах хурдыг тохируулна

3 ▼ Удаан
4 Хурдан
5 △ Нэг удаа арчих

* :Тоноглогдсон автомашинд

## Урд шил арчигч ашиглах




Хөшүүргийг татна.

Урд шил арчигч болон угаагч ажиллана.

Урд шил угаагч ажиллуулах үед урд шил арчигч автоматаар 2 удаа ажиллана.

Их гэрэл цэвэрлэгчтэй автомашин: Их гэрэл асаалттай үед хөшүүргийг татаад барихад их гэрэл цэвэрлэгч 1 удаа ажиллана. Үргэлжлүүлэн их гэрэл угаагч хөшүүргийг таван удаа татах тутамд нэг удаа ажиллана.

## Арын шил арчигч ашиглах




1 ○ Off

2 - - - Тасалдсан горим

3 — Хэвийн ажиллагаа

## Арын шил угаагч ашиглах




Хөшүүргийг татна.

Арын шил арчигч болон угаагч ажиллана.

Угаагч автоматаар ажиллаж Lexus зогсоолд байрлуулахад туслах дэлгэцийн камерыг цэвэрлэнэ.

Арын угаагч ажилласны дараа арын шил арчигч 2 удаа автоматаар ажиллана.

# Жолоодлогын онцлогыг өөрчлөх

## Жолоодлогын горим солих

▶ AVS (Adaptive Variable Suspension) системгүй автомашин




1 Эко горим

Эко горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг зүүн эргүүлж эко горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр эко жолоодлогын горимын индикатор гарна.

2 Спорт горим

Спорт горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт жолоодлогын горимын индикатор гарна.

3 Хэвийн горим

Эко, эсвэл спорт горим сонгогдсон үед жолоодлогын горим сонгох товчийг дарж хэвийн горимд шилжүүлнэ.

▶ AVS (Adaptive Variable Suspension) системтэй автомашин




1 Эко горим

Эко горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг зүүн эргүүлж эко горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр эко жолоодлогын горимын индикатор гарна.

2 Спорт горим

- Спорт S горим

  Спорт S горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт S горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт S жолоодлогын горимын индикатор гарна.
- Спорт S+ горим

Спорт S горимд жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт S+ горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт S+ жолоодлогын горимын индикатор гарна.

3 Хэвийн/Custom горим

Товч дарж хэвийн горим, эсвэл Custom сонгоно. Товч дарах бүрт систем хэвийн горим болон Custom горимын хооронд шилжинэ.

Custom сонгогдсон үед мэдээллийн дэлгэц дээр тус горимын индикатор асна.

Эко горим, спорт горимд байгаа үед товч дарахад систем хэвийн горимд буцна.

# Мултимедиа системийн үндсэн ажиллагаа

## Газрын зураг хөдөлгөх

Газрын зураг хөдөлгөн товшсон цэгийг газрын зургийн төв болгон тохируулах боломжтой.

Газрын зураг дахь цэгийг товших.

- Газрын зургийн төв хөдлөж товшсон цэг рүү шилжинэ.



- Газрын зургийг шилжүүлсэн байрлал, POI-г очих газар, эсвэл тогтмол очдог хаягаар бүртгэх боломжтой. Мөн хэрэв тухайн POI-н мэдээлэл байгаа үед дэлгэцээр гарна.
- Газрын зургийг хөдөлгөөд []-г дарах үед тухайн цэгийг шинэ очих газар, эсвэл замын цэгээр тохируулах боломжтой.
- [], эсвэл []-г дарж автомашины одоогийн байрлал руу буцна.

### МЭДЭЭЛЭЛ

Газрын зургийг дэлгэц дээр товшиж, чирж, эсвэл хөдөлгөн тохируулах боломжтой.

# Жолоодлогын мэдээллийн дэлгэц

## Одоогийн шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц

Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалтын мэдээлэл гаргах боломжтой.

### ■ Одоогийн шатахуун зарцуулалтын дэлгэц




- A Түүхийн мэдээллийг тэглэх
- B Өмнөх 15 минутын шатахуун зарцуулалт
- C Одоогийн шатахуун зарцуулалт
- D Хөдөлгүүр асааснаас хойших автомашины дундаж хурд
- E Туулах боломжтой зай
- F Хөдөлгүүр асааснаас хойших хугацаа.

Дэлгэцээр гарч буй шатахууны дундаж зарцуулалтыг мэдээллийн журмаар ашиглана. Тус зураг нь зөвхөн жишээ бөгөөд бодит байдлаас бага зэрэг өөр байж болно.

### ■ Шатахуун зарцуулалтын түүхийн дэлгэц




- A Хамгийн сүүлийн шатахуун зарцуулалт
- B Хамгийн сайн шатахуун зарцуулалт
- C Өмнөх шатахуун зарцуулалт
- D Түүхийн мэдээллийг устгах
- E Хамгийн сүүлийн шатахуун зарцуулалтын мэдээллийг шинэчлэх

Дэлгэцээр гарч буй шатахууны дундаж зарцуулалтыг мэдээллийн журмаар ашиглана. Тус зураг нь зөвхөн жишээ бөгөөд бодит байдлаас бага зэрэг өөр байж болно.

### Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц харуулах

1. **Үндсэн менюнээс [icon] -г сонгоно.**
2. **[Trip information]-г сонгоно.**
3. **[Current], эсвэл [History]-г сонгоно.**

## Ухаалаг утас, харилцаа холбооны төхөөрөмж холбох

Холболтын төрөл: Bluetooth® , эсвэл Wi-Fi®

### Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх

Гарны оролцоогүй дуудлага, эсвэл Bluetooth® аудио ашиглах үед гар утас, зөөврийн төхөөрөмж холбоно. Бүртгэл дууссан үед Bluetooth® автоматаар мултимедиа систем асаах бүрт холбогдоно.

Apple CarPlay/Android Auto төхөөрөмж USB-р холбогдсон үед Bluetooth® төхөөрөмж автоматаар холбогдоно.

Bluetooth® төхөөрөмж холбогдоогүй үед бүртгэлийн дэлгэцийг жолооны хүрдний [ ] товч удаан дарж гаргана.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Bluetooth & Devices]-г дарна.**

3 **[Manage devices]-г дарна.**

4 **[If not found]-г дарна.**

Өөр төхөөрөмж бүртгэлтэй үед [**Add another device**] > [**If not found**] дараалдаар дарна.



5 **Үндсэн хэсгээс бүртгэх төхөөрөмжийг сонгоно.**

- Төхөөрөмжийн нэрний оронд Bluetooth® хаяг дэлгэцээр гарч болно.
- Үндсэн хэсэг дээр бүртгэх төхөөрөмж гарч ирэхгүй үед Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэх оролдлого хийнэ.
- Зарим загварын Bluetooth® төхөөрөмж нь тодорхой үйлдлийг Bluetooth® төхөөрөмж дээр хийгээгүй үед дэлгэц дээр гарч ирдэггүй. Дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.

6 **Дэлгэцээр гарч буй PIN код Bluetooth® төхөөрөмжтэй таарч байгааг нягтлаад [OK] дарна.**

- Бүртгэл дуусгах үед зарим Bluetooth® төхөөрөмж дээр үйлдэл хийх шаардлагатай байдаг.
- Хэрэглэгчийн профайл бүртгэх зааварчилгаа гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- Үндсэн төхөөрөмжийн тохиргоо гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

- Apple CarPlay-н тохиргоо гарч болно. Ашиглалтыг идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.
- Холболт хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба дэд цэсэн дээр бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

## Бүртгэл Bluetooth® төхөөрөмжөөс хийх

Мултимедиа систем Bluetooth® төхөөрөмжийг хайгаад олохгүй үед мултимедиа системийг Bluetooth® төхөөрөмжөөс хайх боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Bluetooth & Devices]-г дарна.**

**3 [Manage devices]-г дарна.**

Өөр төхөөрөмж өмнө нь бүртгэгдсэн үед [**Add another device**]-г дарна.

**4 Тухайн ашиглах Bluetooth® төхөөрөмж дээр мултимедиа системийг бүртгэнэ.**




- Bluetooth® төхөөрөмжийн ажиллагааны зааврын дагуу үйлдлийг хийнэ.
- Тус Bluetooth® холболтын дэлгэцийг Bluetooth® төхөөрөмж дээр бүртгэл хийхийн өмнө гаргана.

**5 Дэлгэцээр гарах PIN код нь Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгааг нягтлаад [OK]-г дарна.**

- Зарим Bluetooth® төхөөрөмжийг бүртгэл хийх үед удирдах шаардлагатай байдаг.
- Хэрэглэгчийн профайл үүсгэх бүртгэлийн зааварчилгаа дэлгэцээр гарч болно. Зааварчилгааг баримтлана.
- Үндсэн төхөөрөмжийн тохиргоо гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- Apple CarPlay-н тохиргоо гарч болно. Идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.
- Холболт дууссаныг илтгэх мэдээлэл гарч бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр дэд цэс дээр гарна.
- Үйлдэл амжилтгүй болсон үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

## Жолооны хүрдний товчоор удирдах (A төрөл)

Гарны оролцоогүй утасны дуудлага хүлээн авах, дуудлага хийх зэрэг зарим функцийг жолооны хүрдний товч ашиглах удирдах

боломжтой. Мултимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч жолооны хүрдний товчны ажиллагаа өөрчлөгдөнө.




● **Товч дарж удирдана.**

**[+] товч**

Утасны ая, эсвэл ярианы дууны түвшинг нэмнэ.

Үргэлжлүүлэн өөрчлөх үед удаан дарна.

**[-] товч**

Утасны ая, эсвэл ярианы дууны түвшинг хасна.

Үргэлжлүүлэн өөрчлөх үед удаан дарна.

**[] товч**

Дуу хоолойн удирдлагаар дуудлага хийх боломжтой.

Дуу хоолойн удирдлагыг дуусгах үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

**[] товч**

- Мултимедиа систем утасны дэлгэц гаргаагүй үед утасны цэс дэлгэцээр гаргана.
- Мултимедиа системээр дуудлага хийх боломжтой үед дуудлага хийнэ.
- Дуудлага хийх, эсвэл утсаар ярих үед дуудлагыг дуусгана.
- Дуудлага ирэх, эсвэл дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлагад хариулна.

## Жолооны хүрдний товчоор удирдах (B төрөл)

Дуудлага хүлээн авах, хийх зэрэг гарны оролцоогүй утасны зарим функцийг жолооны хүрдний товчоор удирдах боломжтой. Мултимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч тус товчны ажиллагаа өөрчлөгдөнө.

Жолооны хүрдний товч нь электростатик товч болно. Хуруугаар товших үед товч ажиллана. Мултимедиа системийн ажилагааны байдлаас хамаарч дэлгэцээр гарах товчны функц болон байрлал өөр байна.



● **Товч ажиллуулна.**

**[+] товч**

Дуудлагын ая, ярианы дууны түвшин нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

**[-] товч**

Дуудлагын ая, ярианы дууны түвшин хасна.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

**[ ] товч**

Дуу хоолойн командаар дуудлага хийнэ.

Дуу хоолойн командыг дуусгах үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

**[ ] товч**

- Утасны дэлгэц мултимедиа систем дээр гараагүй үед утасны цэс гаргана.
- Мултимедиа системээр дуудлага хийх боломжтой үед дуудлага хийнэ.
- Ярианы дундуур дуудлагыг өөрчлөх/хүлээлгэнд оруулна.
- Дуудлага ирэх, дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлага авна.

**[ ] товч**

- Дуудлага хийх, эсвэл ярианы дундуур яриаг дуусгана.
- Ирж буй дуудлага/хүлээлгэнд байгаа дуудлагыг цуцлана.

## Дуудлагын түүхээс дуудлага хийх

Ирсэн болон гарсан дуудлагын түүхэд бүртгэгдсэн дугаар луу дуудлага хийх боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Recents]-г дарна.**

**3 Хаяг сонгоно.**

Хаягт бүртгэгдээгүй дуудлага дээр зөвхөн дугаар гарна.

**4 Утасны дугаар дээр дарна.**



## Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх

Холбоо барих хаягийг тогтмол ашигладаг жагсаалтад оруулан дуудлага хийх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Favourites]-г дарна.**
3 **Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх хаяг сонгоно.**
4 **Утасны дугаар сонгоно.**



## Холбоо барих хаяг руу дуудлага хийх

Мултимедиа системд бүртгэлтэй хаяг руу дуудлага хийх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Contacts]-г дарна.**
3 **Хаяг сонгоно.**
4 **Утасны дугаар дээр дарна.**



## Дуудлагад хариулах

Дуудлага ирэх үед ая дуугарч ирж буй дуудлагын дэлгэц, эсвэл мэдэгдэл дэлгэц дээр гарна. Дуу хоолойн удирдлагын систем дээр [**Voice support**]-г идэвхжүүлсэн нөхцөлд дуудлага ирэх үед тус систем ажиллана.

● **Дараах аль нэг үйлдлээр дуудлагад хариулна.**



● [ ]-г дарна.

● Жолооны хүрдний [ ] товч дарна.

● Дуу хоолойн команд өгч дуудлагад хариулна.

## Мессежний функцаас дуудлага хийх

Мессежний функцаас гарны оролцоогүй дуудлага хийх боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

● **Цэнхэр өнгөтэй дугаар дээр дарж дуудлага хийнэ.**

Үргэлжилсэн тоог утасны дугаар гэж таниж болно. Мөн бусад улсын дугаар зэрэг зарим утасны дугаарыг танихгүй байж болно.

### И-мэйл, SMS, MMS мессежийн дэлгэцээс дуудлага хийх

И-мэйл, SMS, MMS мессеж илгээгч рүү дуудлага хийх боломжтой. И-мэйлээс дуудлага хийхэд тус холбоо барих хаяг дээр утасны дугаар бүртгэгдсэн байх шаардлагатай.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Messages]-г дарна.**

3 **Хэрэглэгчийн аккаунт сонгоно.**

4 **Мессеж илгээгчийг сонгоно.**



5 **[ ]-г товших эсвэл жолооны хүрдний [ ] товч дарна.**

Хаяг хэрхэн бүртгэснээс хамаарч утасны дугаар сонгох шаардлагатай.

## Apple CarPlay болон Android Auto ашиглах

### USB-р холбон Apple CarPlay ашиглах

USB дата холбогч ашиглан ухаалаг утсыг мултимедиа системд холбон Apple CarPlay ашиглах боломжтой.

1 **Ухаалаг утасны тохиргоон дээр Siri-г асаана.**

2 **USB портод ухаалаг утас холбоно.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарч ирнэ.

● Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.

● Үйлдэл алдаатай болсныг илтгэх дэлгэц гарсан үед зааварчилгааг дагана.

● Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед зааварчилгааг дагана.

● Apple CarPlay-н үндсэн дэлгэц гараагүй үед [ ] > [**Bluetooth & Devices**] > [**Manage devices**], [**Switch**] дараалалаар дарж ашиглах ухаалаг утас сонгоно.

**3 Apple CarPlay-г удирдана.**



Apple CarPlay-г дэмждэг iPhone-н аппликейшн дээр дарж ашиглах боломжтой.

**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

**[ ]/[ ]**

Дэлгэцийг өөрчлөнө.

Удаан дарж Siri-г идэвхжүүлнэ.

## Утасгүй холболтоор Apple CarPlay ашиглах

Мултимедиа системд автомашины утасгүй холболт ашиглан Apple CarPlay ашиглах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**1 Ухаалаг утасны тохиргооны цэснээс Siri-г идэвхжүүлнэ.**

**2 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**3 [Bluetooth & Devices]-г дарна.**

**4 [Manage devices]-г дарна.**

**5 Apple CarPlay-н [Switch]-г дарна.**

**6 Apple CarPlay ашиглах ухаалаг утас сонгоно.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарна.

● Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.

● Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх дэлгэц гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

● Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед зааварчилгааг баримтлана.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**7 Apple CarPlay-г удирдана.**

Apple CarPlay-г дэмждэг iPhone-н апп дээр даран ашиглах боломжтой.



[ ]

Мултимедиа системийн дэлгэц гаргана. Apple CarPlay-н үндсэн дэлгэц дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

[ ]/[ ]

Дэлгэцийг солино.

Удаан дарж Siri-г асаана.

## Android Auto ашиглах

Android Auto-г мултимедиа системд USB холбогчоор ухаалаг утас холбон ашиглах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**1 Холбосон ухаалаг утсанд Android Auto аппликейшн суулгасан байгааг нягтлана.**

**2 USB портод ухаалаг утас холбоно.**

Android Auto-н үндсэн дэлгэц гарч ирнэ.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч дэлгэц анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секундын хугацаа шаардагдаж болно.
- Үйлдэл амжилттай болоогүйг заасан мэдэгдэл гарсан үед зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед дагана.
- Android Auto-н үндсэн дэлгэц гарч ирээгүй үед Android Auto-н [ ] > [**Bluetooth & Devices**] > [**Manage devices**], [**Switch**] -г дарж ашиглах утсаа сонгоно.

**3 Android Auto-г ажиллуулна.**

Android Auto-г дэмждэг аппликейшн дээр дарж ашиглах боломжтой.



[ ]

Мултимедиа системийн дэлгэц гаргана. Android Auto-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

[ ]

Google Assistant-г эхлүүлнэ.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

# Агааржуулалтын системийн удирдлагын самбар

## Option дэлгэцийн товч

▶ 14 инчийн голын дэлгэцтэй загвар




- A Зүүн талын температурын удирдлагын товч
- B Агаарын урсгалын горимын товч
- C Option дэлгэцийн товч
- D Товчлол дэлгэцийн товч

  Функцуудын товчлол тэмдэг гаргах үед сонгоно.
- E [**SYNC**] товч
- F Баруун талын температурын удирдлагын товч
- G [**A/C**] товч
- H Гадна агаар/дотор агаарын горимд солих товч
- I Сэнсний хурдны удирдлагын товч
- J [**OFF**] товч
- K [**AUTO**] товч

▶ 9.8 инчийн голын дэлгэцтэй загвар




- A Зүүн талын температурын удирдлагын товч
- B Агаарын урсгалын горимын товч
- C Option дэлгэцийн товч

D Товчлол дэлгэцийн товч

Функцуудын товчлол тэмдэг гаргах үед сонгоно.

E Баруун талын температурын удирдлагын товч

F [**SYNC**] товч

G [**A/C**] товч

H Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

I Сэнсний хурдны удирдлагын товч

J [**OFF**] товч

K [**AUTO**] товч

## Температур тохируулах

Температур тохируулах хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж температур нэмэх, эсрэг эргүүлж хасна.

[**SYNC**] товчны индикатор ассан үед урд зорчигчийн суудлын температурын тохиргоо жолоочийн суудлын тохиргоотой адил байна.

[**SYNC**] товчны индикатор унтарсан үед [**SYNC**] товч асаавал [**SYNC**] товчны индикатор асч урд зорчигчийн суудлын температур жолоочийн суудлын температурт шилжинэ.

Урд зорчигчийн суудлын температурын тохиргооны товч ажиллах үед [**SYNC**] товчны индикатор унтрах ба урд зорчигчийн суудлын температурын тохиргоог хийх боломжтой болно.

[**A/C**] товчны индикатор унтарсан үед сэнс болон халаагуур ашиглах боломжтой.

## Сэнсний хурд тохируулах

Сэнсний хурд нэмэх үед сэнсний хурд тохируулах [**+**] товч, эсвэл дэлгэцний сэнсний хурд тохируулах тэмдгийг баруун тийш хөдөлгөнө. Сэнсний хурд хасах үед сэнсний хурд тохируулах [**-**] товч, эсвэл дэлгэцний сэнсний хурд тохируулах тэмдгийг зүүн тийш хөдөлгөнө.

[**OFF**] товч сонгож сэнс унтраана.

## Агаарын урсгалын горим солих

Агаарын урсгалын горимын товч дарна

Товч дарах бүрт агаарын урсгалын горим солигдоно.

Сонгосон агаарын урсгалын горимоос хамаарч үлээх агааржуулагч болон агаарын хэмжээ өөрчлөгдөнө.

: Цээж рүү үлээх

: Цээж болон хөл рүү үлээх

: Хөл рүү үлээх

: Хөл рүү үлээж салхины шилний цан арилгагч ажиллах

# Суудал халаагч*

## Урд суудал халаааагч асаах/унтраах

Голын дэлгэц дээр , эсвэл -г сонгоно.

Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO → Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Суудлын агааржуулагчтай автомашин: Ажиллагааны үед түвшний индикатор (шар) асна.

Ажиллагааны үед түвшний индикатор (улаан) асна. [**AUTO**] индикатор автомат ажиллагааны үед асна.

## Арын суудал халаагч асаах/унтраах*

Товч дарна.



Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Суудал халаагч ажиллах үед түвшний индикатор (шар) асна.

* :Тоноглогдсон автомашинд

## Суудлын агааржуулагч*

Суудал дотор байрласан сэнс ашиглан суудлын гадаргууг агааржуулна.

### Суудлын агааржуулагч (урд) асаах/унтраах

Голын дэлгэц дээр  , эсвэл  -г сонгоно.

Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар солигдоно.

Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Ажиллах үед түвшний индикатор (цэнхэр) асна. [**AUTO**] индикатор автомат ажиллагааны үед асна.

*:Тоноглогдсон автомашинд

## USB портод холбох

Ухаалаг утас, зөөврийн тоглуулагч зэрэг төхөөрөмж холбоно.

● **USB холбогчийг портод хийнэ.**



USB флаш залгах үед шууд USB портод хийнэ.

# Хаалга түгжих/тайлах

## Түлхүүрийн алсын удирдлага ашиглан ажиллуулах

### Түлхүүрийн алсын удирдлагаар хаалга түгжих, тайлах




1 Бүх хаалга түгжинэ
2 Бүх хаалга тайлна

## Хаалга түгжих товч ашиглах

Entry функц, түлхүүрийн алсын удирдлага, эсвэл хаалга түгжих товчоор хаалга түгжих, тайлах боломжтой.

### Хаалга түгжих товчоор хаалга түгжих/тайлах




1 товч дарна.

Бүх хаалга түгжигдэнэ.

A индикатор асна.

2 товч дарна.

Бүх хаалганы түгжээ тайлагдана.

A унтарна.

# Хаалга нээх/хаах

## Хаалга нээх

### ▶ Автомашины гадна талаас нээх




Хаалга түгжээтэй үед:

Электрон түлхүүрийг биедээ авч хаалганы бариулны хаалга нээх товч A дарж хаалга нээнэ.

Электрон түлхүүрийн таних хүрээнд хаалганы бариулны дотор талд байрлах хаалга нээх товчийг A дарна.

Хаалга түгжээтэй үед:

Хаалганы бариулны хаалга нээх товч A дарж хаалга нээнэ.

хаалганы бариулны дотор талд байрлах хаалга нээх товчийг A дарна.

### ▶ Автомашины дотор талаас нээх




Жолоочийн хаалга:

Хаалга түгжээтэй байсан ч хаалга нээх товчны A урд талыг дарж хаалга нээнэ.

Хаалганы түгжээ тайлагдах ба хаалганы түгжээний индикатор унтарна.

Зорчигчийн хаалга:

Хаалга түгжих товч дарж түгжээ тайлаад хаалга нээх товчны A урд талыг дарж хаалга нээнэ.

Хаалганы түгжээ тайлагдах ба хаалганы түгжээний индикатор унтарна.

## Автомашины дотор талаас хойд хаалга нээхээс сэргийлэх (хүүхэд хамгаалах түгжээ)

Түгжээ түгжигдсэн үед хойд хаалгыг дотор талаас нээх боломжгүй.




1 Түгжээ тайлах
2 Түгжих

Тус түгжээг бага насны хүүхэд хойд хаалга нээхээс сэргийлж түгжинэ. Хойд 2 хаалганы товчийг доош дарж түгжинэ.

# Цонх нээх ба хаах

## Автомат цонхны товчоор ажиллуулах

### Автомат цонхны товчоор цонх нээх/хаах




1 Автомат цонхны товчийг хагас өргөнө.

Товч өргөх хугацаанд цонх хаагдана.

2 Автомат цонхны товчийг гүйцэд өргөнө.

Цонх автоматаар гүйцэд хаагдана.

Үйлдэл дунд цонхыг зогсоох үед товчийг эсрэг чиглэлд ажиллуулна.

3 Автомат цонхны товчийг хагас дарна.

Товч дарах хугацаанд цонх нээгдэнэ.

4 Автомат цонхны товчийг гүйцэд дарна.

Цонх автоматаар гүйцэд нээгдэнэ.

Үйлдэл дунд цонхыг зогсоох үед товчийг эсрэг чиглэлд ажиллуулна.

## Түлхүүрийн алсын удирдлага ашиглан ажиллуулах

Түлхүүрийн алсын удирдлагаар автомат цонх нээх, хаах боломжтой.*1

### Түлхүүрийн алсын удирдлагаар цонх нээх

Түлхүүрийн алсын удирдлагаар хаалганы түгжээ тайлангаа нэгэн зэрэг цонхнууд нээх боломжтой.*2

*1 : Тус тохиргоог та өөрийн Lexus дилер дээр хийлгэх шаардлагатай.

*2 : Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.



● **Түлхүүрийн алсын удирдлаганы түгжээ тайлах товчийг удаан дарна.**

Хаалганы түгжээ тайлагдах ба дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэнэ.

Дуут дохио дуугарч цонх болон дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэж байгааг анхааруулна.

### Түлхүүрийн алсын удирдлага ашиглан цонх хаах

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан бүх хаалга түгжэнгээ цонх хаах боломжтой.*3



● **Түлхүүрийн алсын удирдлаганы хаах товчийг удаан дарна.**

Бүх хаалга түгжигдэх ба цонх ба дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий * хаагдана.

Дуут дохио дуугарч цонх болон дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэж/хаагдаж байгааг илтгэнэ.

Хаалга бүрэн түгжигдэж цонх хаагдсаныг нягтлана.

## Цонх санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх

Цонх түгжих товч нь бага насны хүүхэд санамсаргүйгээр цонх нээх, хаахаас сэргийлэх зориулалттай.

* : Тоноглогдсон автомашинд

*3 : Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.

Цонх түгжих товч дарна.




Индикатор A асах ба зорчигчийн цонхнууд түгжигдэнэ.

## Дээврийн нээлхий ашиглах*

Бүхээг дэх тав тухтай мэдрэмжийг бүрдүүлж дээврийн нээлхийг нээх, дээш өргөх боломжтой.

### Дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслах функц

Дараах функцууд нь дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслана.

● Хавчихаас хамгаалах функц

Дээврийн нээлхий хаагдах, эсвэл өргөсөн нээлхий доош буух үед нээлхий болон араамны завсар эд зүйл мэдрэгдсэн үед нээлхийн хөдөлгөөн зогсож буцаж бага зэрэг нээгдэнэ.

● Дээврийн нээлхий нээлттэй байгааг анхааруулах дохио

Дээврийн нээлхий нээлттэй үед асаах товч унтрааж жолоочийн хаалга нээхэд дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

### Дээврийн нээлхий нээх

товч дарна.*4

Салхины чимээг багасгах зорилгоор дээврийн нээлхий бүрэн онгойх байрлалаас бага зэрэг дутуу зогсоно.



### Дээврийн нээлхий хаах

товч дарна.*5



* :Тоноглогдсон автомашинд

*4 : Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед товчны аль нэг талыг зөөлөн дарна.

*5 : Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарна.

## Дээврийн нээлхийг дээш өргөх

товч дарна.*6



## Дээврийн нээлхий доош буулгах

товч дарна.*7



*6 : Дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарж дээврийн нээлхийг зогсооно.

*7 : Дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарж ажиллаж буй дээврийн нээлхийг зогсооно.

## Тээшний хаалганы функц ба ажиллагаа

Тээшний хаалгыг дараах дарааллаар түгжих/тайлах болон нээх/хаах боломжтой.

### Тээшний хаалга нээх товчоор тээшний хаалга ажиллуулах

#### Тээшний хаалга нээх товчоор тээшний хаалга автоматаар нээх (тээшний автомат хаалгатай автомашин)

Хаалганы түгжээ тайлагдсан үед тээшний хаалга нээх товч дарна.



#### Тээшний хаалга нээх товч ашиглан тээшний хаалга гараар нээх (тээшний автомат хаалгагүй автомашин)



Тээшний хаалга нээх товч дарангаа тээшний хаалга өргөнө.

## Тээшний хаалганы товч ашиглан тээшний хаалга ажиллуулах*

### Тээшний хаалганы товчоор тээшний хаалга нээх/хаах

-г дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар хаагдана.



## Салон дахь тээшний автомат хаалганы товчоор тээшний автомат хаалга ажиллуулах*

### Тээшний хаалга дотор талаас нээх/хаах

-г 1 секунд дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

Тээшний хаалга нээгдэх/хаагдах явцад товч дарж хаалга зогсооно.

Хаалга зогссон үед товч дарахад тээшний хаалга эсрэг чиглэлд хөдлөнө.



## Smart entry & start системээр тээшний хаалга нээх

### Smart entry & start системээр тээшний хаалга түгжих/тайлах




1 1-г дарна.

Бүх хаалганы түгжээ тайлагдана. Нөгөөтэйгүүр хаалга түгжсэн үед 3 секундын дотор тайлагдахгүй.

2 2-г дарна.

Бүх хаалга түгжигдэнэ. Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг нягтлана.

*:Тоноглогдсон автомашинд

## Түлхүүрийн алсын удирдлагаар тээшний автомат хаалга ажиллуулах

### Түлхүүрийн алсын удирдлагаар тээшний хаалга түгжих/тайлах




1 🔒-г дарна.

Тээшний хаалга болон бүх хаалга түгжигдэнэ.

2 🔓-г дарна.

Тээшний болон бусад бүх хаалга тайлагдана.

## Kick сенсор ашиглан тээшний хаалга ажиллуулах→ Х.71

### Kick сенсор ашиглан тээшний хаалга нээх/хаах (Гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин)




A Kick сенсор
B Kick сенсорын ажиллах хүрээ
C Smart entry & start системийн мэдрэх хүрээ

1 **Биедээ электрон түлхүүртэй үед арын гуперны Smart entry & start системийн ажиллах хүрээ болох 50-с 70 см (19.7-с 27.6 in.) зайд зогсоно.**

2 **Арын гупернээс 10 см (3.9 in.) зайд хөлөө оруулаад гаргана.**

Гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулах үед арын гуперт хөлөөр хүрэхгүй.

3 **Дохио дуугарах үед хөлөө гаргана. Дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэж хаагдана.**

## Шатахуун цэнэглэх

### Шатахуун цэнэглэхийн өмнө

- Асаах товч унтрааж бүх цонх хаалга хаана.
- Шатахууны төрлийг шалгана.

## Шатахууны савны тог онгойлгох

**1 Шатахууны сав нээгч товч дарна.**

Шатахууны савны таг нээгдэнэ.



**2 Тагийг зөөлөн эргүүлж аваад суурин дээр тогтооно.**



# Анхааруулах гэрэл ба индикатор

## Анхааруулах гэрлийн жагсаалт

Системд доголдол үүссэн үед тухайн системийн анхааруулах гэрэл анхааруулга өгч асна.

| | |
|---|---|
|  (улаан) | Тоормосны системийн анхааруулах гэрэл[1] |
|  (шар) | Тоормосны системийн анхааруулах гэрэл[1] |
|  | Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл[2] |
|  | Аккумулятор цэнэглэх системийн анхааруулах гэрэл[2] |
|  | Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл[2] |
|  | Доголдол анхааруулах гэрэл[1] |
|  | SRS анхааруулах гэрэл[1] |
|   | ABS анхааруулах гэрэл[1] |
|  | Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл[2] |
|  (улаан) | Электрон жолооны механизмын анхааруулах гэрэл[1] |
|  (шар) | Электрон жолооны механизмын анхааруулах гэрэл[1] |
|  | Шатахуун багассаныг анхааруулах гэрэл |

| | |
|---|---|
|  | Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл |
|  | Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл (HUD дэлгэцгүй автомашин)* |
|  | Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл (HUD дэлгэцтэй автомашин)* |
|  | Дугуйн даралт анхааруулах гэрэл[1]→ Х.73<br>(3) |
| <br>(шаргал) | LDA индикатор |
| <br>(шаргал) | LTA индикатор |
| <br>(анивчих) | Stop & Start cancel индикатор[1]* |
| <br>(анивчих) | Stop & Start индикатор*[1] |
|  | Lexus parking assist-sensor OFF индикатор*[1] |
| <br>(шаргал) | Хурд баригчийн индикатор |
|  | Динамик радарын хурд баригчийн индикатор |
|  | Жолоодлогод туслах мэдээллийн индикатор[1] |

* :Тоноглогдсон автомашинд

| | |
|---|---|
|  (анивчих эсвэл асах) | PCS анхааруулах гэрэл(1) |
|  | Шарвалтын индикатор(1) |
|  (анивчих) | Зогсоолын тоормосны индикатор |
|  (анивчих) | Тоормос баригчийн ажиллагааны индикатор(1) |

(1) Энэ гэрлүүд нь асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед системийн ажиллагааг шалгаж байгааг илтгэж асах ба хөдөлгүүр асах, эсвэл хэдэн секундын хугацаа өнгөрсний дараа унтарна. Гэрэл асахгүй, эсвэл унтрахгүй байх нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ. Та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.

(2) Тус гэрэл нь мэдээллийн дэлгэц дээр асна.

(3) Температурын өөрчлөлт зэргээс шалтгаалан дугуйн хий өөрөө гарах зэргээс шалтгаалж дугуйн хийн даралт анхааруулах гэрэл асч болно. Дугуйн даралтыг заасан хэмжээнд тохируулах ба хэдэн минутын дараа гэрэл унтарна. Дугуйны даралт тохируулсан ч гэрэл унтрахгүй үед та өөрийн Lexus дилер дээр системийг шалгуулна уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг "Хэрэглэгчийн гарын авлагаас харна уу.".

## Индикаторын жагсаалт

Индикаторууд нь жолоочид автомашины олон төрлийн системийн ажиллагааг мэдээлнэ.

| | |
|---|---|
|  | Эргэх дохионы индикатор |
|  | Оврын гэрлийн индикатор |
|  | Холын гэрлийн индикатор |
|  | AHS индикатор*(1)<br>AHB индикатор*(1) |

*: Тоноглогдсон автомашинд

| | |
|---|---|
|  | Урд манангийн гэрлийн индикатор* |
|  | Арын манангийн гэрлийн индикатор |
|  | PCS анхааруулах гэрэл(1)(3) |
|  | Хурд баригчийн индикатор |
|  | Динамик радарын хурд баригчийн индикатор |
|  | LDA индикатор |
|  | LTA индикатор |
|  | BSM хажуугийн толины индикатор*(2) |
|  | Lexus parking assist-sensor OFF индикатор*(3)(1) |
|  | Жолоодлогод туслах мэдээллийн индикатор(1)(3) |
|  | Stop & Start индикатор*(1) |
|  | Stop & Start cancel индикатор(1)(3)* |
|  (анивчих) | Шарвалтын индикатор(1) |
|  | VSC OFF индикатор(1)(3) |
|  | Зогсоолын тоормосны индикатор(1) |
|  | Тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор(1) |

| | |
|---|---|
|  | Тоормос баригчийн ажиллагааны индикатор[1] |
|  | Эко жолоодлогын индикатор[1] |
|  | Гадна агаарын нам хэмийн индикатор[4] |
|  | [**PASSENGER AIR BAG**] индикатор[5]* |
|  | Уруу замд туслах удирдлагын системийн индикатор* |
|  | Эко жолоодлогын горимын индикатор |
|  | Sport горимын индикатор[6] |
|  | Sport S горимын индикатор[7] |
|  | Sport S+ горимын индикатор[7] |
|  | Custom горимын индикатор[7] |
|  | Trail Mode индикатор* |

(1) Энэ гэрлүүд нь асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед системийн ажиллагааг шалгаж байгааг илтгэж асах ба хөдөлгүүр асах, эсвэл хэдэн секундын хугацаа өнгөрсний дараа унтарна. Гэрэл асахгүй, эсвэл унтрахгүй байх нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

(2) Тус гэрэл хажуугийн толин дээр асна.

(3) Тус гэрэл систем унтрах үед асна.

(4) Гадна агаарын хэм 3°C (37°F)-с бага үед тус индикатор 10 секунд анивчаад асна.

(5) Тус гэрэл урд салоны/хувийн гэрэл дээр асна.

(6) F SPORT загвараас бусад

(7) F SPORT загвар

Дэлгэрэнгүйг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

## Механик түлхүүр ашиглах



Түгжээ тайлах товчийг даран механик түлхүүрийг сугалан гаргана.

Механик түлхүүрийг зөвхөн нэг тийш харуулан хийх боломжтой ховил электрон түлхүүрт байдаг. Түлхүүрийн нүхэнд механик түлхүүр орохгүй үед механик түлхүүрийг нөгөө тийш нь харуулан хийнэ. Механик түлхүүрийг хэрэглэсний дараа электрон түлхүүрт буцаан хийж хадгалах ба электрон түлхүүрээс салгаж болохгүй. Электрон түлхүүрний зай суусан, эсвэл entry функцийн хэвийн ажиллагаа алдагдсан, эсвэл аккумулятор суусан үед таньд механик түлхүүр шаардлагатай болно.

## Хаалга түгжих/тайлах



**1 Хаалганы бариулын завсар хуванцар карт зэргийг хийж тагийг авна.**

Гэмтээхээс сэргийлж таганд хэт хүчээр харьцаж болохгүй.

**2 Механик түлхүүрээр дараах үйлдлийг хийнэ:**




1. Бүх хаалганы түгжээ тайлах
2. Бүх хаалга түгжих

## Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед гар аргаар тайлах бариулаар нээх боломжтой.

### Гар аргаар хаалга нээх бариул ашиглах

▶ Автомашины гадна тал




Гар аргаар хаалга нээх A бариулыг татаж хаалга нээнэ.

Хэвийн нөхцөлд гар аргаар хаалга нээх бариулаар хаалга нээх боломжгүй.

Гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг идэвхжүүлж хаалга нээнэ.→ Х.79

▶ Автомашины дотор тал




Гар аргаар хаалга нээх A бариулыг 2 удаа татаж хаалга нээнэ.

Бариулыг нэг удаа татахад ажиллагаа идэвхжинэ. Дахин татах үед хаалга нээгдэнэ.

### Механик түлхүүр ашиглан хаалганы гадна бариул идэвхжүүлэх

Механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлан гадна бариулын ажиллагааг идэвхжүүлэх боломжтой.

**1 Хуванцар карт зэргийг хаалганы бариулны завсар хийгээд тагийг авна.**

Гэмтээхээс сэргийлж тагийг хүчтэй дарж болохгүй.



**2 Механик түлхүүр ашиглан цоожны цилиндрийг түгжээ тайлах байрлалд эргүүлж бариулын ажиллагааг идэвхжүүлнэ.**

Механик түлхүүр нь нэг талдаа ховилтой ба зөвхөн нэг талаараа орох боломжтой.

Цоожны цилиндрт түлхүүр орохгүй үед нөгөө тийш харуулан дахин оролдоно.



Хаалганы бариулны ажиллагаа идэвхжинэ.

## Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед хөдөлгүүр асаах

**1 Араа P байрлалд байгааг нягтлаад тоормос гишгэнэ.**

**2 Асаах товчинд электрон түлхүүрийн Lexus эмблемтэй талыг хүргэнэ.**

Электрон түлхүүр танигдах үед дохио дуугарах ба асаах товч ON горимд шилжинэ.

Хэрэв Smart entry & start системийг өөрчлөх боломжтой тохиргоогоор цуцласан үед асаах товч ACC горимд шилжинэ.



**3 Хаазны дөрөөг сайтар гишгээд мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарсныг нягтлана.**

**4 Асаах товч дарна.**

Дээрх үйлдлийг хийсэн ч хөдөлгүүр асахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Электрон түлхүүрийн зайны цэнэг муудсан үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна. Шинэ зайгаар солино. Зай солих тухай дэлгэрэнгүй мэдээллийг "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с харна уу.

Таньд тусламж шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

## Хөдөлгүүр асахгүй үед

Асаах үйлдлийг зөв хийж гүйцэтгэсэн эсэхийг шалгана.

Хөдөлгүүр асаах оролдлого хийх үед тоормосны дөрөө сайтар гишгэнэ.

Хөдөлгүүр асахгүй үед "ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА"-с дэлгэрэнгүй мэдээллийг харах, эсвэл өөрийн Lexus дилертээ хандана уу.

## ТЭМДЭГЛЭЛ